



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/230

Булган

"Байгалиа хамгаалъя" нэгдсэн
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ойн тухай хуулийн 29.1.6, 29.1.7, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Цагдаагийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга


Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

2. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэдэд эрх зүйн мэдлэг мэдээлэл олгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр тараах материал, телевизийн шторк нэвтрүүлэг бэлтгэх, байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг шалгах арга хэмжээг зохион байгуулсугай.

3. Уг арга хэмжээнд шаардагдах 1000000 /нэг сая/ төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний "Байгаль орчны багц хуулийн хяналт шалгалт" төсөл, арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Нэгдсэн арга хэмжээний тайланг нэгтгэн, 2019 оны 06 сарын 01-ний дотор танилцуулахыг ажлын хэсэсэг /Б.Одхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190244